

| | |
|------------------------------|---|
| 著者(英) | Lkhagvasuren Ichinkhorloo |
| journal or publication title | Senri Ethnological Reports |
| volume | 42 |
| page range | 1-225 |
| year | 2003-10-25 |
| URL | http://doi.org/10.15021/00001890 |

Төгсгөлийн үг

И.Лхагвасүрэн

Социалист нийгмийг байгуулахын төлөө Монголд өрнөж байсан их ажилд гар бие оролцож, хувь нэмрээ оруулсан түүхэн хүмүүс уншигч та бүхэнтэй бага ч гэсэн өөрийн дурсамжаа хуваалцлаа.

Монгол улсын хөдөлмөрийн баатар Ринчингийн Минжүүрийн нэрийг дуулаагүй хүн өнөөгийн Монголд байхгүй гэж хэлж болох биз ээ. Бага залуу насандаа амьдралын хатуу, бэрхийг амсаж, мал маллаж өссөн тэрээр өөрийн авъяас билэг, идэвх зүтгэлээрээ гайхамшигтай амжилтанд хүрч чадсан юм. Багаасаа мал маллах Монгол арга, ухааныг ахмад үеийнхнээсээ өвлөн авсан нь хожим Архангай аймгийн Их тамир сумын “Гэрэлт зам” нэгдлийн даргаар ажиллаж байхдаа нэгдлийн малын тоо, толгойг өсгөж үржүүлэх, ашиг шим, арьс, шир, ноос, ноолуурыг бүрэн ашиглахад нь хэрэг болсон гэдэг. Өдгөө Р.Минжүүр гуай нас сүүдэр хэдий нь 90 дөхөж байгаа ч ухаан санаа саруул, үг хэл хурц, үйл хөдлөл хөнгөн, шаламгай хивээрээ байна. Энэ бүхэн бол мал дагасаны буян гэж тэр хэлэх дуртай.

Паавангийн Дамдин бол “Дамдин сайд” гэдэг нэрээр өрнө, дорно дахинд алдаршсан хүн. Баруун Монголын жирийн малчин айлын гэрт төрж, өссөн тэрээр Монголын Аж Үйлдвэрийн Яамны сайдын албыг тасралтгүй 30 гаруй жил хашсан юм. Сайдын албан тушаалыг эрх ямба биш, улс орныхоо өмнө хүлээсэн том хариуцлага гэж үзвэл, Монголд орчин үеийн аж үйлдвэрийн салбар цоо шинээр үүсэж, богино хугацаанд амжилттай хөгжсөн бүх “хариуцлага”-ыг түүнд үүрүүлж болно. Түүний намтар нь Монголд аж үйлдвэр хөгжсөн түүхтэйгээ ижил гайхалтай сонин. 17 настайдаа аав, ээжийнхээ хамт анх удаа Улаанбаатар хотод орж ирсэн нь ирээдүйд Монгол улсын Аж Үйлдвэрийн Яамны сайд болох их замын эхлэл нь байсан гэдэг. Нутагтаа байхдаа ээжийгээ дагаж насанд хүрэгчдийн бичиг үсэг сурах бүлгэмд очиж, Монгол бичиг унших төдий л сурснаас өөр сурч мэдсэн зүйлээр тааруухан Улаанбаатарт орж ирж байсан тэрээр, тухайн үедээ л ганцхан байсан санхүү, эдийн засгийн техникумид жил дараалан “онц” сурч улмаар Зөвлөлтөд /хуучин нэрээр/ эдийн засгийн дээд сургуульд сурч эдийн засагч болж ирээд ажил хөдөлмөр эрхлэж яваад Аж Үйлвэрийн Яамны сайдаар томилогдохдоо ердөө л 29 настай байсан гэдэг. Энэ бол 1960 онд болсон үйл явдал байж. Түүнээс хойш Монголд боссон үйлдвэр болгон энэ хүний нэртэй холбоотой гэж хэлж болно. 1990 онд 60 нас хүрч хуулиар олгогдсон насны тэтгэвэрт гарахдаа анх ажилд орсон газраа л байсан гэж тэр хэлэх

дуртай. Сайн малчин төдийгүй, сайн дархан гэгдэж олны хүндэтгэлийг хүлээж явсан Пааван гуайн бага хүү ингэж 20-р зууны Монголын түүхийг бичилцсэн юм.

Шаравын Гунгаадорж бол 50-аад оны сүүлч 60-аад оны эхээр манай оронд “Атар газрыг эзэмших хөдөлгөөн” ид өрнөж байхад агрономич мэргэжилтэй байсан цөөхөн хэдэн хүний нэг. Амгалангийн Сангийн аж ахуйд тарьж байсан тариа ногоондоо хоргодоод алдарт Лоохуузыг дуудахад очоогүйгээсээ болж түүнээс зэм хүртэж явсан удаатай.

Зэрлэг ургамал түүж, эм хийгээд хүний өвчинг илааршуулдаг маарамба лам байсныхаа төлөө цаазын тавцан дээр нэг гарч, азаар амь мултарч, арван жил шоронд суусан түүний эцгийн намтар бол 20-р зуунд монголчууд бидний туулсан замын л нэг хэсэг. Орос оронд очиж, зэрлэг биш таримал ургамалын мэргэжилтэн, агрономич болж ирсэн Гунгаадорж хүүгийнх нь улс орондоо хөдөлмөрлөсөн түүх урт бөгөөд баян. Монгол улсын ерөнхий сайдаар томилогдоод байхдаа ч тэр ажил хөдөлмөрийн гараагаа эхлэсэн аграномчийнхаа ажил, Монгол орны газар тариалангийн өнөө, ирээдүйн хөгжлийн асуудлыг анхаарлаасаа огт холдуулаагүй явсан гэдэг. Ийм нэг “Монгол тариачин” эдүгээ УИХ-ын гишүүн, УИХ-ын Байгаль орчин, Хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны даргын албыг хашиж байна.

Монголын шинэ үеийн уран зохиолын түүхийг сөхөж нэг үзэх юм бол тэнд Ардын уран зохиолч, төрийн шагналт, яруу найрагч Дэндэвийн Пүрэвдорж гэдэг хүний нэр “Газарт галтай хамт, тэнгэрт нартай хамт дархлагдсан” байхыг үзэж болно. Монгол хүн “Чингис” гэдэг нэрийг хэлж болдоггүй байсан үзэл, сурталын хатуу, ширүүн он, жилүүдэд түүний бичсэн “Чингис” найраглалыг Монголын залуу үеийнхэн цээжээрээ уншдаг байсан гэдэг. Ингэж тэр “хэлмэгдэж” биш, мандаж явлаа. Монголд өрнөсөн ардчисан хөдөлгөөнийг дэмжиж, үгээ хэлж, үйл явдалд нь оролцож явсан анхны 4 зохиолчийн нэг.

Ийм хүмүүсийн намтрыг эцэс төгсгөлгүй үргэлжлүүлж болно. 20-р зууны Монголын түүх бол ийм л хүмүүсийн намтараар дүүрэн билээ. Цаг үе улиран өнгөрсөөр 20-р зуун нэгэнт алслан оджээ. 20-р зуунтай хамт социализм ч бас л улиран одсон байна. Ирж байгаа шинэ зуун бидний хувьд ямар зуун болох вэ? Энэ асуултанд хариулахын тулд бид заавал өнгөрсөн түүхээ эргэн харах ёстой. Үйл явдалд оролцож, өөрийн намтар түүхээрээ 20-р зууны Монголын түүхийг бичилцсэн эдгээр хүмүүсийн ярьсан яриа болж өнгөрсөн үйл явдлуудыг дахин нэг сануулах нь дамжиггүй. Уншигч авхай та мэргэн оюундаа тунгаан соёрхоно уу.

Төгсгөлд нь энэ номыг бүтээж, буй болгох санаачлагыг гаргаж, холын Япон орноос зорин ирж, уулзсан хүн бүрийн ярьсан яриа, хэлсэн үг бүрийг

анхааралтай чагнаж, тэмдэглэл хийж, видео болон энгийн хальсанд буулгаж өгсөн манай хамтран зүтгэгч Япон улсын Осака хот дахь угсаатны зүйн музейн профессор, Монгол судлаач эрдэмтэн Коногаяадаа хувиасаа болон өөрийн дурсамжаа хуваалцсан бүх хүний нэрийн өмнөөс талархалаа илэрхийлэхийг хүсэж байна.

Мөн энэ номыг Япон хэлэнд орчуулах хүнд бөгөөд хариуцлагатай ажлыг чадварлаг гүйцэтгэсэн хуучин танил доктор Ф.Мако болон Кондо авхай нартаа бас талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Энэ номыг бүтээх ажилд өөрийн хувь нэмрийг оруулж, тусалсан бүх хүмүүст талархалаа дахин илэрхийлж байгааг минь болгоон соёрхоно уу.